БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@btdalaivanaudit.mn
Вэб хуудас: www.btdalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ХЕРО ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Санал дүгнэлт

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "ХЕРО ФИНАНС ББСБ" ХХК-ийн санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "ХЕРО ФИНАНС ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан дүрэм, журам зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн ба эдгээр стандартын дагуу бидний хүлээх хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол Улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад үндэслэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд анхаарал хандуулахуйц аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч "ХЕРО ФИНАНС ББСБ" ХХК нь энэ тайланг бэлтгэдэг. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

bakertilly INTERNATIONAL

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Байгууллагын Удирдлага нь СТОУС, түүнд нийцүүлэн баталсан заавар, журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Байгууллагын засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.

- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2023 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 28-НИЙ ӨДӨР

ХЕРО ФИНАНС ББСБ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2022.12.31. мянган төгрөг	2021.12.31. мянган төгрөг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө		160,987.70	287,415.40
Үнэт цаас			
Зээл /цэвэр/		711,874.00	479,971.30
Хуримтлуулж тооцсон хүүний авлага		44,302.30	8,000.10
Бусад авлага		901.80	11,117.40
Бусад хөрөнгө		1,394.90	1,329.70
Эргэлтийн хөрөнгийн дүн		**919,460.70**	**787,833.90**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)		80,642.40	84,806.90
Биет бус хөрөнгө (цэвэр)			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**80,642.40**	**84,806.90**
НИЙТ ХӨРӨНГӨ		**1,000,103.10**	**872,640.80**
ЭХ ҮҮСВЭР			
ӨР ТӨЛБӨР			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл			
Өрийн бичгээрх өглөг			
Бусад өр төлбөр			
Бусад өглөг		23,864.70	2,055.80
Өр төлбөрийн дүн		**23,864.70**	**2,055.80**
Өөрийн хөрөнгө			
Энгийн хувьцаа		600,000.00	600,000.00
Хандивын капитал		87,256.50	87,256.50
Нийгмийн хөгжлийн сан			
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		288,981.90	183,328.50
Өөрийн хөрөнгийн дүн		**976,238.40**	**870,585.00**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		**1,000,103.10**	**872,640.80**

Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ХЕРО ФИНАНС ББСБ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	2022.12.31. мянган төгрөг	2021.12.31. мянган төгрөг
Хүү болон түүнтэй адилтгах орлого		291,540.60	259,399.60
Хүүний зардал			
Цэвэр хүүний орлого		**291,540.60**	**259,399.60**
Хүүний бус орлого		25,531.80	36,252.00
Хүүний бус зардал:			
Боловсон хүчинтэй холбоотой зардал		62,607.30	50,390.10
Бусад зардал		19,234.80	19,205.50
Эрсдэлийн сангийн зардал		6,081.30	49,735.20
Үйл ажиллагааны ашиг		**229,149.00**	**176,320.80**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого			
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		645.30	941.20
Татварын өмнөх ашиг (алдагдал)		**228,503.70**	**175,379.60**
Орлогын албан татварын зардал		22,850.30	1,753.80
Тайлант жилийн татварын дараах ашиг		**205,653.40**	**173,625.80**
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Эрсдэлийн сангийн нөөцийн (өсөлт), бууралт			
Нийгмийн хөгжлийн сангийн (өсөлт), бууралт			
Нийт бусад дэлгэрэнгүй орлого		**205,653.40**	**173,625.80**

Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ХЕРО ФИНАНС ББСБ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2022.12.31. мянган төгрөг	2021.12.31. мянган төгрөг
1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(125,782.40)	178,084.00
1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**1,334,267.80**	**1,311,886.30**
Зээлийн хүүний орлого	291,540.60	270,087.00
Харилцах дансны хүүний орлого		
Банкин дахь хадгаламжийн хүүний орлого		
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	7,418.90	5,039.40
Зээл төлөлтийн орлого	1,035,308.30	1,036,759.90
1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**1,460,050.20**	**1,133,802.30**
Үндсэн ба нэмэгдэл цалин	55,650.90	45,172.70
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж		
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	13,173.10	5,217.40
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	7,637.80	1,770.70
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	1,635.90	1,607.00
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	286.20	654.70
Татвар, даатгалд төлсөн мөнгө	16,257.00	20,533.30
Ногдол ашгаар олгосон мөнгө	90,000.00	86,400.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	500.00	500.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжинд төлсөн мөнгө	1,280.00	1,280.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн мөнгө	229.30	7,629.70
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	1,273,400.00	963,036.80
2.ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(645.30)	(941.20)
2.1 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого		-
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого		
Ногдол ашгийн орлого		
Бусад		
2.2 Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**645.30**	**941.20**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	645.30	941.2
Бусад		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(126,427.70)**	**177,142.80**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**287,415.40**	**110,272.60**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**160,987.70**	**287,415.40**

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХЕРО ФИНАНС ББСБ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувьцаат капитал мянган төгрөг	Дахин үнэлгээний нэмэгдэл мянган төгрөг	Бусад нөөц мянган төгрөг	Хуримтлагдсан ашиг мянган төгрөг	Нийт мянган төгрөг
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	**600,000.00**	**87,256.50**		**9,702.70**	**696,959.20**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					
Залруулагдсан үлдэгдэл	600,000.00	87,256.50	0.00	9,702.70	696,959.20
Хувьцаат капиталын өсөлт					
Нийгмийн хөгжлийн сан					
Эрсдэлийн сангийн нөөц					
Тайлант үеийн цэвэр ашиг				173,625.80	173,625.80
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	**600,000.00**	**87,256.50**		**183,328.50**	**870,585.00**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					
Залруулагдсан үлдэгдэл	600,000.00	87,256.50	-	183,328.50	870,585.00
Хувьцаат капиталын өсөлт					-
Эрсдэлийн сангийн нөөц					
Тайлант үеийн цэвэр ашиг				205,653.40	205,653.40
Ногдол ашиг				100,000.00	100,000.00
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	**600,000.00**	**87,256.50**	**0.00**	**288,981.90**	**976,238.40**

Хавсаргасан тайлангууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL